

— 2019 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

“ЛэндМН ББСБ” ХК

Агуулга

| | |
|--------------------------|-----------|
| Компанийн тухай | 03 |
| Бизнесийн үйл ажиллагаа | 10 |
| Санхүүгийн үйл ажиллагаа | 19 |
| Компанийн засаглал | 24 |

Компанийн тухай



Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



“

Бидний үндсэн зээлийн үйлчилгээ 2019 онд 2 дахин нэмэгдэж, 4.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа.

”

Эрхэм хүндэт хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагч байгууллагууд болон харилцагчид та бүхний энэ өдрийн амар амгаланг эрэн мэндчилж байна.

"ЛэндМН ББСБ" ХК ололт амжилт, хөгжил дэвшилтээр дүүрэн 2019 оны санхүү үйл ажиллагааны тайлангаа та бүхэндээ хүргэж байгааг хүлээн авна уу.

Монгол улсын финтек салбарт шинэ шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэмэгдэж, зах зээлийн бодит өрсөлдөөний орчныг эрүүлээр бий болгон хөгжсөөр байгаа бөгөөд 2019 оны хувьд цаашдын чиг хандлагыг тодорхойлохуйц үйл явдлууд дүүрэн байлаа. Бидний хувьд өдөр тутам өөрчлөгдөж байгаа хэрэглэгчийн зан төлөвт тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд туршиж, бидний үндсэн үйлчилгээ болох зээлийн үйл ажиллалаа 2019 онд 2 дахин нэмэгдэж нийт хэтэвч болон зээлийн хэрэглэгчийн тоо 365 мянгад хүрч зээлийн багц 19 тэрбум төгрөгөөс 50 тэрбум төгрөгт хүрч 2.6 дахин өссөн амжилттайгаар 2019 оны санхүүгийн жилээ үдэж байна.

2019 онд Mintos Financial Platform олон улсын санхүүгийн байгууллагаас ЛэндМН ББСБ ХК В+ үнэлгээ авч Mintos Financial Platform-р дамжуулан санхүүжилт татдаг 65 олон улсын санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч компаниудаас 13 дугаарт бичигдсэн нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц гэдгээ ахин баталсан үйл явдал боллоо.

СЗХ-оос Факторинг болон Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг авсан бөгөөд "Мирэ Эссет Секьюритис Монгол" ҮЦК-тай 4 сая ам.долларын санхүүжилтийг итгэлцлийн үйлчилгээгээр татах санамж бичиг зурж, гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдаас нийт 14.6 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлсэн нь оны онцлох үйл явдлуудын нэг байлаа.

Нийгмийн хариуцлагын хүрээнд өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээндээ сайн үйлсийн нэмэлт платформыг хөгжүүлсэн нь нийгэмд үйлчлэх олон талт хамтын ажиллагааг дэмжсэн чухал ажил болсон юм. Цаашлаад хувь жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан татан авалтын зээлийн үйлчилгээг гаргаж харилцагч, нийлүүлэгчдийг холбосон чухал хэрэгцээт бүтээгдэхүүн гаргаснаараа хэрэглэгчдийн талархлыг хүлээгээд байна.

Бидний өнгөрсөн онд хийсэн олон төрлийн ажлуудыг нэгтгэн дүгнэж банк санхүүгийн салбарын хөгжлийн түвшинг тодорхойлогч "AsiaMoney" сэтгүүлээс 2019 оны Монголын шилдэг дижитал санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээр LendMN-ийг тодруулсан нь бидний амжилтыг бататгалаа.

2019 онд 4.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласны үр дүнд хөрөнгө оруулагчдадаа 1.2 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар ТУЗ-д санал оруулсан бөгөөд энэ нь өмнөх жилээс даруй 50% өсөлттэй дүн юм.

"ЛэндМН ББСБ" ХК-ийн хувьд 2020 ондоо үйл ажиллагаагаа улам өргөжүүлж бичил зээлийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй шинэ бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэн зах зээлд нэвтрүүлж Монгол улсын санхүүгийн зах зээл тэр дундаа финтек салбарын хөгжлийн тэргүүлэгч байр сууриа улам баталгаажуулахаар зорьж байна.

Хувьцаа эзэмшигч хөрөнгө оруулагч нартаа баярлалаа.

Хүндэтгэсэн:

"ЛэндМН ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирал
О.Болдбаатар



ҮНЭТ ЗҮЙЛС

Шилдэг баг хамт олон, дэвшилтэт технологи дээр суурилсан үйлчилгээ, харилцагчийн итгэл найдвар, илүү ихийг хүсэн мөрөөдсөн, хүлээлгэсэн итгэл нь ЛэндМН-ийн үнэт зүйл байна.



АЛСЫН ХАРАА

Дэвшилтэт технологи дээр суурилсан, дэлхийн энтэй санхүүгийн үйлчилгээний хөтөч байна.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж чаддаггүй хүмүүст хүрэх шинэлэг үйлчилгээгээр хэрэглэгчдээ хангасан нийгмийн хариуцлагыг гүнээ ухамсарласан хамт олон байна.

2019 оны онцлох үйл явдлууд

2019

СЗХ-оос Факторинг болон Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авсан. Итгэлцлийн үйлчилгээгээр гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдаас нийт 14.6 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлээ.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгууллаа. Энэхүү хурлаар компанийн 2018 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн дүгнэлт болон компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг баталж, 2019 онд хийхээр төлөвлөж буй ажлуудаас товч танилцуулан ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг томиллоо.

Хувьцаа эзэмшигчдэдээ 800 сая төгрөгийн ногдол ашгийг тараалаа.

Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг албан ёсоор нэвтрүүллээ. Дэлхийн 80 гаруй улсад үйл ажиллагаагаа явуулдаг “Thunes” компанитай хамтын ажиллагаагаа эхлүүлэн БНСУ-аас олон улсын мөнгөн гуйвуулгын компани болох Hanpass-тай хамтран LendMN апп-аар дамжуулан Солонгос улсаас мөнгө хүлээн авах боломжтой боллоо.

Татан авалтын зээлийн шинэ бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүллээ. Энэхүү зээлийн бүтээгдэхүүн нь жижиглэнгийн худалдаа эрхлэгчдэд зориулсан бөгөөд үндэсний үйлдвэрлэгч болон импортын бараа бүтээгдэхүүний бөөний борлуулагчдаас татан авалт хийхэд зориулсан үйлчилгээ юм.

Санхүүгийн Зохицуулах Хорооноос гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авлаа.

Хандивын платформыг амжилттай нэвтрүүллээ. Энэхүү хандивын платформ нь Монголд үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын нийгмийн сайн сайхны төлөөх төслүүдийг дэмжиж шаардлагатай мөнгөн дүнг босгоход туслах технологийн хамгийн төгс шийдэл юм.

“Thunes” компанитай эхлүүлсэн хамтын ажиллагааны хүрээнд Австрали улсаас Монгол улс руу мөнгөн гуйвуулга хийх боломжтой боллоо. Тус хамтын ажиллагааны хүрээнд харилцагчдадаа Америк болон Европын улсуудаас мөнгөн гуйвуулга хүлээн авах боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.



Монголын хамгийн том хөгжмийн наадам болох “Playtime” олон улсын амьд хөгжмийн наадмын стратегийн түншээр хамтран ажиллалаа. Хамтын ажиллагааны хүрээнд тасалбар борлуулалт болон наадмын 3 хоногийн турш бүх төлбөр тооцоо, шилжүүлгийг LendMN аппликейшнээр хийх хялбар шийдлийг залуучууддаа санал болголоо.

Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК-тай 4 сая ам.долларын санхүүжилтийг итгэлцлийн үйлчилгээгээр татах санамж бичиг зурагдлаа.

Хэрэглэгчдийнхээ санал хүсэлт, хэрэгцээ шаардлагад үндэслэн дунд хугацааны зээлийн бүтээгдэхүүнийг туршилтын журмаар зах зээлд нэвтрүүлээ.

LendMN
аппликейшны
таталт
1 саяд хүрлээ.

1 MILLION
DOWNLOADS


Mintos Financial Platform олон улсын санхүүгийн байгууллагаас B+ үнэлгээ авлаа. Mintos Financial Platform-р дамжуулан санхүүжилт татдаг 65 олон улсын санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч компаниудаас 13 дугаарт бичигдлээ.

mintos

Санхүүгийн Зохицуулах Хорооноос 7.4 тэрбум төгрөгийн бондыг хаалттай хүрээнд худалдах зөвшөөрөл авлаа.

Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан үйл ажиллагааг Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн дагуу эрхлэх, түүнтэй холбоотой “ЛэндМН ББСБ” ХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани байгуулах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2.5 тэрбум төгрөгөөр тогтоох шийдвэрийг гаргав.

2020



Банк санхүүгийн салбарын хөгжлийн түвшинг тодорхойлогч “AsiaMoney” сэтгүүлээс 2019 оны Монголын шилдэг дижитал санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээр LendMN-ийг тодрууллаа.

Mintos Financial Platform олон улсын санхүүгийн байгууллагатай хамтын ажиллагаагаа эхлүүлээ.



Компанийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө



55
ЖИЛ

Нэг хэрэглэгч зээл авахад хамгийн багадаа 3 цаг зарцуулдаг гэж үзвэл бид онлайнаар хамгийн шуурхай зээлийн үйлчилгээг үзүүлснээр 161 мянган харилцагчийн зээл авахад зарцуулах 483 мянган цаг буюу 55 жилтэй тэнцэх хугацааг хэмнэх боломжийг олгожээ.




3500
МОД

Нэг удаагийн зээл олголтод дунджаар 15 хуудас цаас зарцуулдаг. Бид 1.9 сая удаагийн зээлийг цахим хэлбэрээр баримт бүрдүүлэхгүй олгосноор 146 тонн цаас хэмнэж 3,500 ширхэг мод аварчээ.



423
Тэрбум
төгрөг

Барьцаагүй зээлийн үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгчдийн 423 тэрбум төгрөгийн эд хөрөнгө, нэр хүндээ барьцаалах үйлдлээс сэргийлж, барьцаа хөрөнгийн асуудлыг бүрэн шийдвэрлэлээ.



477
Сая төгрөг

Хэрэглэгчдэд хэтэвчийн үйлчилгээг шимтгэлгүй үзүүлснээр нийт 477 сая төгрөгийн банкны шимтгэлийн зардлыг хэмнэжээ.



800
Сая төгрөг

ЛэндМН ББСБ ХК хувьцаа эзэмшигчдэдээ 800 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилжээ.

Компанийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө



4.2
Тэрбум
төгрөг

Компанийн хөрөнгө оруулагчдад
төлсөн нийт хүү



1.1
Тэрбум
төгрөг

ЛэндМН ББСБ ХК-ийн төлсөн ААН-ийн
нийт татварын хэмжээ



411
Сая төгрөг

Нийгмийн даатгалын шимтгэлд байгууллагаас 214 сая, ажилчдаас
197 сая төгрөгийг төлжээ.



98
Ажлын
байр

Шинээр бүтэн цагийн 26, гэрээт 5 нийт 31 ажлын байр бий болгон,
нийт цалин урамшуулал, хангамж болон тэтгэмжид 2.0 тэрбум
төгрөгийг зарцуулжээ.



1.5
Тэрбум
төгрөг

Гуравдагч этгээдээс авсан бараа, ажил, үйлчилгээний худалдан
авалт

- Худалдан авалт 534 сая төгрөг
- Хамтын ажиллагаа болон ивээн тэтгэлэг 1 тэрбум төгрөг

Бизнесийн үйл ажиллагаа



2019 оны өсөлтүүд

Бүртгүүлсэн хэрэглэгч

712,988

x2.1
дахин өссөн



Зээлийн харилцагч


166,385

x1.7
дахин өссөн

Олгосон зээлийн тоо

1.9
сая удаа

x2.6
дахин өссөн




Олгосон зээлийн хэмжээ

424
тэрбум

x2.8
дахин өссөн

Зээлийн үйл ажиллагаа


Гэрээт харилцагчийн тоо



Хүйсийн харьцаа




Насны ангиллаар




Байршлаар


 Улаанбаатар  Орон нутаг




Олгосон зээлийн тоо
(Мянган зээл)




Олгосон зээлийн дүн
(Тэрбум төгрөг)



Зээлийн багц
(Тэрбум төгрөг)



ББСБ Салбарын зээлдэгчдийн тоо
(2019.III улирлын байдлаар)



Татан авалтын зээл

Энэхүү зээлийн бүтээгдэхүүн нь жижиглэнгийн худалдаа эрхлэгчдэд зориулсан бөгөөд үндэсний үйлдвэрлэгч болон импортын бүтээгдэхүүний бөөний борлуулагчдаас татан авалт хийхэд зориулсан зээлийн үйлчилгээ юм.

2500

Нийт мерчантын тоо

1.3 тэрбум

Нийт олгосон зээл



Татан авалтын зээлийг ашиглан 7 хоногт 2-3 удаа татан авалт хийгээд төлбөрөө хүүгүйгээр эргүүлж төлөх нь бүтээгдэхүүнээ хангалттай хэмжээгээр татан авах боломжийг бүрдүүлж өгч байгаа. Бараа бүтээгдэхүүн татан авалтанд зориулан бэлэн мөнгө бэлдээд суудаг үе өнгөрчээ. Хамтрагч байгууллагуудын төлбөрөө LendMN аппликейшнээрээ төлөөд явдаг болсон.

Инжир март

ХУД, 3-р хороо, Нарны хороолол, 9-р байранд байрлах супермаркет



LendMN аппликейшны татан авалтын зээлийн үйлчилгээ нь эдийн засгийн хувьд том хөшүүрэг болж байгаа. Өөрөөр хэлбэл энэхүү үйлчилгээг авснаар барааны төрлөө нэмэгдүүлж, үүнийгээ дагаад эрэлт нэмэгдэж орлого 30-50% нэмэгдэж байгаа. Нийлүүлэгч байгууллагуудтайгаа төлбөр тооцоогоо Лэндээрээ хийхэд их хялбар аль аль талдаа хамгийн хялбар шийдэл болж чадаж байгаа.

Оранж супермаркет

БЗД, Баянмонгол хороолол



Манай компани нь ЛэндМН ББСБ ХК-тай 2019 оны 6-р сараас хамтран ажиллан харилцагч байгууллагуудаа LendMN-ийн татан авалтын зээлийн үйлчилгээнд хамрууллаа. Энэ хугацаанд борлуулагч болон компанийн бэлэн мөнгөний эрсдэлийг бууруулан, борлуулалтын хэмжээ болон цар хүрээг тэлсэн амжилттай үр дүн гарч байгааг дуулгахад таатай байна.

Мах Импэкс ХК

Борлуулалтын албаны дарга



ЛэндМН ББСБ ХК-тай хамтран ажилласнаар найман нэрийн дэлгүүрүүдээс тасралтгүй татан авалтын захиалга авч бүтээгдэхүүний нийлүүлэлтээ жигд хугацаанд хийх боломжийг бүрдүүлж байна. Энэхүү технологийн дэвшлийг ашиглан хамтран ажиллаж буй бүх талууд богино хугацаанд өндөр үр дүнг гарган ажиллаж байгаад таатай байна.

Максимус Дистрибьюшн ХХК

Борлуулалтын менежер

Хамтын ажиллагаатай байгууллагууд



Хямдралын купон

LendMN аппликейшнээр дамжуулан хэрэглэгчдэдээ тухайн цаг үеийн хамгийн эрэлттэй бүтээгдэхүүн үйлчилгээг 20-90%-ийн хямдралтай үнээр худалдан авах боломжийг олгож ажиллалаа. Түүнчлэн хамтран ажиллагч 178 байгууллагуудын 1.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлчилгээний худалдан авалтын төлбөр тооцоог LendMN аппликейшнээр дамжуулан хийж гүйцэтгэсэн байна.

178

Хамтрагч байгууллагууд

634 сая ₮

Бодит хэмнэлт



LendMN гэдэг нэр миний толгойд шууд БОЛНО гэсэн үг шиг буудаг. Яагаад дэлхийн жишигт нийцсэн санхүүгийн үйлчилгээг бид ашиглаж болохгүй гэж? Яагаад байгууллагын хамтын ажиллагаа нээлттэй, соёлтой, ёсзүйтэй байж болохгүй гэж? Энэ бүх асуултын хариултыг LendMN-тэй хамтран ажиллахдаа авч чаддаг шүү.

Синдерелла Клиник ХХК

Маркетингийн албаны дарга О.Буянжаргал



Кофе шопын үйлчилгээний хамгийн чухал шалгуур бол түргэн шуурхай үйлчилгээ байдаг. Энэхүү шаардлагад маань бүрэн нийцсэн төлбөр тооцооны шийдлийг LendMN санал болгодог. Мөн LendMN аппликейшнд купон байршуулахад маркетингийн бусад сувгаас илүү үр дүнтэй байдгаас гадна байнгын үйлчлүүлэгчтэй болоход маань тусалж байгаа.

Caffe Bene Mongolia

Үйл ажиллагаа хариуцсан захирал Б.Энхбат



Би LendMN аппликейшны хоол захиалгын үйлчилгээ болон купонд хамгийн дуртай. Өдрийн хоолоо оффистоо захиалахад халуунаараа ирдэг. Яг авахаар төлөвлөж байгаа зүйл купоноор орвол алдалгүй худалдан авахыг хичээдэг.

Д.Алтанбилэг

Эрэгтэй, 26 настай



Би өдөр бүр LendMN аппликейшны купонуудыг орж шалгадаг. Найз нөхдийн уулзалт, төрсөн өдрийн урилга аваад бэлэг бэлдэж амжихгүй байвал Лэндийн купоноос аваад л найздаа бэлэглэчихдэг. Цаг хугацааны болон санхүүгийн хамгийн сайн хэмнэлтийг хийж чаддаг шүү.

Б.Болорцэцэг

Эмэгтэй, 32 настай



SAMSUNG

PC mall.



Gegeenten
ENTERTAINMENT CENTER

TOUS les JOURS



technozone
FIRST TO DELIVER



P e d r o

НОМИН
ЭЛЕКТРОНИКС



JACK'S COFFEE
ROASTERY

LIPOO CINEMA
IMAX

COSÉ
COSMETICS

2
SWAROVSKI



DYRBERG/KERN
COPENHAGEN

ААЗХҮР
НОМН ИХ ДЭЛГҮҮР



BISHRELT
BEAUTY

Төлбөр тооцооны үйлчилгээ



2019 онд “ЛэндМН ББСБ” ХК нь төлбөр тооцооны үйлчилгээний цар хүрээгээ нэмэгдүүлэх зорилгоор “Анд Системс” ХХК-тай хамтран хэрэглэгчдийн өдөр тутам ашигладаг үйлчилгээг LendMN аппликейшнээс хялбараар авч, Лэнд хэтэвчээр төлбөрөө төлөх олон боломжуудыг нэвтрүүлээ. Тайлант хугацааны эцсийн байдлаар хэрэглэгчид 23 төрлийн нэмэлт үйлчилгээг LendMN аппликейшнээс авч, төлбөр тооцоогоо хийх боломжтой болсон байна.



Togloom Trade



Онлайн дэлгүүр



Comedy lab



Алалц хож



Гар урлал



Гадаад аялал



UB Comedy



Үзвэрийн билет



Номин даатгал



Цэцэг хүргэлт



TokTok Delivery



Хандив



Кино тасалбар



Номын худалдаа



Эрүүл хүнс



Өдрийн хоол



Нислэгийн тийз



Made in Mongolia



Хаан Даатгал



Амралт зугаалга



Практикал даатгал



Flower Fairy



Event Space

Дуудлагын төв

Дуудлагын төв нь нийт 30 ажилчидтайгаар хэрэглэгчдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн ажилладаг бөгөөд 2019 оны турш нийт 1 сая удаагийн зээлийн үйлчилгээ, аппликейшн ашиглалт болон бусад үйлчилгээний лавлагааг үзүүлж тэдгээрийн 92.8%-д амжилттай үйлчлэн асуудлыг нь бүрэн шийдвэрлэсэн байна.

15 сек

Хүлээлгийн
түвшин

1 сая

Нийт
Дуудлага

92.8%

Амжилттай
үйлчилсэн



45'774

Сошиал сувгаар
үйлчилсэн /PM/



12'401

И-мэйлээр
үйлчилсэн



25'871


Мессэжээр
үйлчилсэн



Хүний нөөц



Хүйсийн харьцаа



29.1 Дундаж нас



БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

98%
Дээд

2%
Бүрэн дунд

— Санхүүгийн үйл ажиллагаа



2019 оны өсөлтүүд

Нийт актив

58.1
тэрбум
төгрөг

x2.4
дахин өссөн



Зээлийн багц


50.0
тэрбум
төгрөг

x2.6
дахин өссөн

Нийт орлого

18.3
тэрбум
төгрөг

x2.5
дахин өссөн



Цэвэр ашиг

4.9
тэрбум

x1.9
дахин өссөн

Санхүүгийн байдлын тайлан /аудитлагдсан/

| MNT'000 | 2017 | 2018 | 2019 |
|---|------------------|-------------------|-------------------|
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 2,391,070 | 4,218,150 | 2,382,196 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 4,289,481 | 19,199,366 | 49,457,676 |
| Бусад хөрөнгө | 92,666 | 260,086 | 4,756,978 |
| Үндсэн хөрөнгө | 265,252 | 387,784 | 1,162,101 |
| Биет бус хөрөнгө | 90,958 | 258,051 | 342,002 |
| Нийт хөрөнгө | 7,129,427 | 24,323,437 | 58,100,953 |
| Хаалттай бондын өглөг | 1,022,356 | 6,565,017 | 3,601,164 |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | - | - | 13,845,212 |
| Банкны зээлийн өглөг | - | 3,527,400 | 21,133,646 |
| Цахим хэтэвчээрх өглөг | - | 682,695 | 964,265 |
| Бусад өглөг | 88,532 | 193,950 | 1,358,188 |
| Нийт өр төлбөр | 1,110,888 | 10,969,062 | 40,902,475 |
| Хувьцаат капитал | 6,000,000 | 10,756,859 | 10,490,773 |
| Бусад | - | 57,348 | 57,348 |
| Хуримтлагдсан ашиг | 18,539 | 2,540,168 | 6,650,357 |
| Нийт эздийн өмч | 6,018,539 | 13,354,375 | 17,198,478 |
| Нийт өр төлбөр болон эздийн өмч | 7,129,427 | 24,323,437 | 58,100,953 |


Аудитлагдсан санхүүгийн тайлантай дараах холбоосоор орж танилцах боломжтой.
<https://lend.mn/postdynamic.html?article=1435253065991843887>

Орлого, үр дүнгийн тайлан /аудитлагдсан/

| MNT'000 | 2017 | 2018 | 2019 |
|---|------------------|--------------------|--------------------|
| Шимтгэл болон түүнтэй адилтгах орлого | 961,707 | 7,143,319 | 18,321,082 |
| Хүүгийн зардал | (57,934) | (511,934) | (4,654,241) |
| Цэвэр орлого | 903,773 | 6,631,385 | 13,666,841 |
| Зээлийн болзошгүй эрсдлийн нөөцийн зардал | (15,351) | (408,525) | (1,618,802) |
| Үйл ажиллагааны цэвэр орлого | 888,422 | 6,222,860 | 12,048,039 |
| Удирдлагын болон ҮА-ны зардал | (815,624) | (3,278,064) | (6,016,664) |
| IPO-той холбоотой нэг удаагийн зардал | (40,099) | (79,446) | - |
| Нийт зардал | (855,723) | (3,357,510) | (6,016,664) |
| Татварын өмнөх ашиг | 32,699 | 2,865,350 | 6,031,375 |
| Татварын зардал | (8,778) | (305,037) | (1,121,186) |
| Цэвэр ашиг | 23,921 | 2,560,313 | 4,910,189 |


Аудитлагдсан санхүүгийн тайлантай дараах холбоосоор орж танилцах боломжтой.
<https://lend.mn/postdynamic.html?article=1435253065991843887>

Нийт актив, пассив
(Тэрбум төгрөг)




■ Нийт актив ■ Нийт пассив

Нийт болон өөрийн хөрөнгийн өгөөж
(Хувь)



■ Нийт хөрөнгийн өгөөж ■ Өөрийн хөрөнгийн өгөөж

Орлого болон Цэвэр ашиг
(Тэрбум төгрөг)



■ Зээлийн үйл ажиллагааны орлого ■ Цэвэр ашиг

Компанийн засаглал



Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайлан

Үйл ажиллагаагаа эхэлснээс хойш 1 жил гаруйхан хугацааны дотор Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд хамгийн амжилттай олон нийтэд хувьцаагаа гарган нээлттэй компани болсон, 3 жилийн түүхтэй шинэ, залуу компанийн хувьд компанийн засаглалын зохистой бүтэц, тогтолцоог хэрэгжүүлж, түүнийгээ улам бүр бэхжүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна.

ЛэндМН ББСБ ХК нь хувьцаа эзэмшигчид, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгахад анхаарал хандуулж, компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийг улирал бүр олон нийтэд тайлагнан, хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гарсан шийдвэрийн мэдээллийг тухай бүр нээлттэй мэдээлж байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) компанийн үйл ажиллагааг зохистой төвшинд удирдах, стратегийн зорилтод хүрэхэд хяналт тавин ажиллаж байгаагийн зэрэгцээ гүйцэтгэх удирдлагыг компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ нь бизнесийн төрөл бүрийн салбарын шилдэг мэргэжилтэн, арвин туршлагатай удирдах ажилтнуудаас бүрдсэн нь компанийн үйл ажиллагааг улам бүр бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байна. ТУЗ-ийн гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас 1 жилийн хугацаатай томилдог ба 2019 оны 3 сард Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн 7 гишүүнийг улираан томилж, Ердийн гишүүнээр Мэтью Вэлч, Хараат бус гишүүнээр Ч.Номинг шинээр томилсон. 2019 оны 8 дугаар сард ТУЗ-ийн ердийн гишүүн Мэтью Вэлч өөрийн хүсэлтээр ердийн гишүүнээс чөлөөлөгдсөнөөр ТУЗ нь ердийн 5, хараат бус 3, нийт 8 гишүүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байсан О.Болдбаатарыг Компанийн Гүйцэтгэх захирлаар томилогдсонтой холбоотой 2019 оны 8 сарын 15-ны өдөр ТУЗ-ийн даргаар Б.Дэлгэржаргалыг сонгов.

ТУЗ нь дэргэдээ Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг бүхий дараах 3 хороотой ба хороодын бүрэлдэхүүнийг Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан шаардлагын дагуу ТУЗ-өөс томилдог.

- Эрсдэлийн удирдлагын хороо (ЭУХ)
- Аудитын хороо
- Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо (ЗНДЦУХ)

2019 онд ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтүүдтэй холбоотой хороодын бүрэлдэхүүнд 2 удаа өөрчлөлт орсон болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн



ТУЗ-ийн дарга
Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

АНД Системс ХХК
Үйл ажиллагаа хариуцсан захирал
ЭУХ-ны дарга



ТУЗ-ийн ердийн гишүүн
О.БОЛДБААТАР

ЛэндМН ББСБ ХК Гүйцэтгэх захирал
ЭУХ-ны гишүүн



ТУЗ-ийн ердийн гишүүн
В.БАЯРСАЙХАН

АНД Глобал
Үйл ажиллагаа хариуцсан захирал
ЭУХ-ны гишүүн



ТУЗ-ийн ердийн гишүүн
Н.ЦЭВЭГМИД

Мирэ Эссет Секьюритис Монгол
ҮЦК ХХК Гүйцэтгэх захирал
ЭУХ-ны гишүүн
Аудитын хорооны гишүүн



ТУЗ-ийн ердийн гишүүн
С.ЭНХ-АМГАЛАН

Петровис ойл ХХК Гүйцэтгэх захирал
ЗНДЦУХ-ны дарга



ТУЗ-ийн хараат бус гишүүн
Ч.НОМИН

Монгол телевиз ХХК
Гүйцэтгэх захирал
ЭУХ-ны гишүүн
ЗНДЦУХ-ны гишүүн



ТУЗ-ийн хараат бус гишүүн
С.БОРГИЛ

Сэргэлт Консалтинг Групп
Гүйцэтгэх захирал
Аудитын хорооны гишүүн
ЗНДЦУХ-ны гишүүн



ТУЗ-ийн хараат бус гишүүн
Ж.ЖАРГАЛСҮРЭН

Далайван аудит ХХК
Гүйцэтгэх захирал
Аудитын хорооны дарга

Эрх бүхий албан тушаалтнууд



О.БОЛДБААТАР

Гүйцэтгэх захирал



М.ТҮВШИНЖАРГАЛ

Санхүү, үйл ажиллагааны
газрын захирал



Д.ОТГОНГЭРЭЛ

Ерөнхий нягтлан бодогч



Т.БОЛОРМАА

Бүтээгдэхүүн хөгжлийн
хэлтсийн менежер



Э.БАТЗАЯА

Харилцагчийн үйлчилгээний
хэлтсийн менежер



М.БЯМБАСҮРЭН


Эрсдэл хянан нийцүүлэлтийн
газрын ахлах менежер

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

2019 онд компанийн ТУЗ нь хуучин болон шинэчилсэн бүрэлдэхүүнээр ээлжит 5, ээлжит бус 11, нийт 16 удаа хуралдав. Нийт хуралд оролцсон гишүүдийн ирц 92% байлаа. Тайлант онд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо 3 удаа, Аудитын хороо 3 удаа, Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшуулаллын хороо 4 удаа хуралдаж, холбогдох тайланг хэлэлцсэнээс гадна, ТУЗ-ийн ээлжит хурлаар хэлэлцэж, шийдвэрлэх асуудлуудад урьдчилсан дүгнэлт, санал гарган ажиллалаа.

- 2019 онд ТУЗ нийт 62 тогтоол, шийдвэр гаргаснаас 33 шийдвэрийг ээлжит хурлаар, 29 шийдвэрийг эчнээ санал хураалтаар гаргасан байна.
- ТУЗ нь компанийн үйл ажиллагааны өсөлтийг хангах шаардлагатай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарч, банк болон толгой компанид зээлийн хүсэлт гаргах, хэлцэл хийх, гадаад валютын эх үүсвэрийн эрсдэлийг удирдах чиглэлээр 28 шийдвэр гаргаснаас банк, санхүүгийн байгууллагын шийдвэрээс хамаарч 12 шийдвэр нь хэрэгжээгүй байна.

ТУЗ-ийн хурал, шийдвэр




■ Хурлын тоо ■ Шийдвэрийн тоо

ТУЗ-ийн шийдвэр



ТУЗ-ийн шийдвэрийн хэрэгжилт



■ Хэрэгжсэн ■ Хэрэгжиж байгаа ■ Хүлээгдэж байгаа ■ Цуцлагдсан

- 2019 онд компанийн үйл ажиллагааг зохистой удирдах чиглэлээр хэд хэдэн бодлогын бичиг баримтыг баталсны дотор эрсдэлийн удирдлагын бодлого, санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлого, эх үүсвэрийн төлөвлөгөө, зээл, түүнтэй адилтгах активыг ангилах, сан байгуулах, зарцуулах бодлого зэргийг баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, зохих хяналтыг тавин ажиллаж байна.
- Компанийн удирдлага зохион байгуулалттай холбоотой хэд хэдэн шийдвэр гаргасны дотор компанийн өсөлттэй холбоотойгоор гүйцэтгэх удирдлагыг өөрчлөх шийдвэр гаргалаа. Компанийг үүсгэн байгуулагчдын нэг “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга О.Болдбаатарыг компанийн Гүйцэтгэх захирлаар томилсон нь хөрөнгө оруулагчид болон хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн компанийн зорилтыг хэрэгжүүлж, хөгжлийн дараагийн төвшинд шилжихэд чухал ач холбогдолтой юм.
- Өнгөрсөн онд их хэмжээний болон ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл, эх үүсвэрийн болон үйл ажиллагаатай холбоотой зарим хэлцэл байгуулах тухай нийт 11 шийдвэрийг хуулийн дагуу гаргасан байна. Компани ТУЗ-ийн шийдвэрийн үндсэн дээр сонирхлын зөрчилтэй этгээдтэй хэлцэл хийдэг ба шийдвэрийг ТУЗ-ийн сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхийн саналаар гаргадаг.
- 2019 оны 12 сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар ЛэндМН ББСБ ХК-ийн 100%-ийн хөрөнгө оруулалттай охин компани байгуулж, шаардлагатай хөрөнгө оруулалт хийх, Үндэсний төлбөрийн системийн хуулийн дагуу Монголбанкинд тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах, цахим хэтэвч, төлбөр тооцооны үйлчилгээг уг тусгай зөвшөөрлийн дагуу эрхлэх шийдвэрийг гаргалаа.
- Компани 2017 оноос санхүүгийн тайланг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Эрнст энд Янг Аудит Монголиа” ХХК-иар хийлгэж ирсэн ба 2019 оны санхүүгийн тайланд аудит хийлгэхээр дахин сонгосон болно. 2018 болон 2019 оны аудитлагдсан тайлангийн үр дүнг ТУЗ-с хангалттай гэж дүгнэн, 2018 оны цэвэр ашгаас 800 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилсан бол 2019 оны цэвэр ашгаас 1.2 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэрийг гаргалаа.

Эрсдэлийн Удирдлага

“ЛэндМН ББСБ” ХК нь санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийг зохистой түвшинд удирдах, бизнесийн нэгжүүдэд стратеги, төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор 2019 онд Эрсдэлийн удирдлагын бие даасан газрыг байгууллаа.

Эрсдэлийн удирдлагын хүрээнд Эрсдэлийн удирдлагын бодлого, Санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлого, Эх үүсвэрийн төлөвлөгөө, зээл түүнтэй адилтгах, активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлогыг тус тус ТУЗ-ийн хурлаар батлуулж өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу компанийн эрсдэлийн удирдлагын “Гурван шатлалт хамгаалалт”-ын тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байгаа төдийгүй компанийн бизнесийн үйл ажиллагаа, стратегийг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хязгаарыг тогтоож, тогтмол хяналт тавин, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд улирал бүр тайлагнаж байна.

Зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд шаардлагатай бодлогуудыг тодорхойлж, зээлийн бүтээгдэхүүн болон зээлийн эргэн төлөлтийг сайжруулах, хяналтыг хэрэгжүүлэх байдлаар зээлийн эрсдэлийг удирдаж байгаа төдийгүй зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг биелүүлэн ажиллаж байна.

Тайлант жилд зээлийн багцын чанарын үзүүлэлт тогтвортой байсан бөгөөд компанийн зүгээс зээлийн багцын чанарт илүү анхаарч ажиллалаа. 2019 оны эцсийн байдлаар “ЛэндМН ББСБ” ХК-ийн нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээл 3.47% байгаа бөгөөд Банк бус санхүүгийн салбарын чанаргүй зээлийн багц 9.6%, банкны салбарын хэрэглээний зээлийн (цалин, тэтгэврийн зээлээс бусад) чанаргүй зээлийн багц 4.04% байгаатай харьцуулахад “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьд зээлийн эрсдэлийг боломжит түвшинд удирдан ажиллаж байгааг илтгэх үзүүлэлт юм.

Цаашлаад тайлант оны эцсийн байдлаар зээл эргэн төлөгдөхөд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах сангийн хэмжээг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 89%-тай тэнцэх хэмжээнд байгуулсан.

Иргэдэд олгосон зээлийн чанаргүй зээлийн үзүүлэлт

*/*Монголбанкны болон Санхүүгийн зохицуулах хорооны тайлан дээр үндэслэн тооцооллыг гаргав./*



1 - Нийт 539 ББСБ орсон болно

2 - Нийт 8 Финтек ББСБ орсон болно

Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлтийг 2019 онд бүрэн хангаж ажилласныг дараах хүснэгт илтгэж байна.

| ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | 2017 | 2018 | 2019 |
|--|----------|--------|---------------|
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа >10 | 73.80% | 52.10% | 26.00% |
| Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа >20 | 73.80% | 52.10% | 26.01% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт >8 | 2156.30% | 38.00% | 17.80% |
| Нэг зээлдэгч, түүний холбогдох этгээдэд олгох зээл, актив, баталгаа <30 | 0.01% | 0.01% | 0.04% |
| ББСБ-ийн холбогдох этгээдэд олгох зээл, актив, баталгаа <10 | 0.01% | 0.01% | 0.03% |
| Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт) <+40 | 0.07% | 0.03% | -5.30% |
| Эрсдэлийн сангийн харьцаа | 0.37 | 2.31 | 3.10 |


Хууль, хянан нийцүүлэлтийн эрсдэлийн удирдлагын хүрээнд хяналтыг сайжруулж, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллав. Нөгөөтэйгүүр Монгол Улсын хууль, дүрэм, журам, зохицуулагч байгууллагын бодлого, журам, шаардлагыг ханган ажилласан.

2019 онд ЛэндМН ББСБ ХК нь бизнесийн үйл ажиллагаагаа эрхлэхдээ хариуцлагатай, ёс зүйтэй ажиллах эрмэлзлэлээ баталгаажуулах зорилгоор “Ёс зүйн дүрэм”-ийг батлуулан, хэрэгжүүлж ажиллаж байна.


Хувьцааны мэдээлэл

- 2019 оны 2-р сард Монголын Хөрөнгийн Биржийн үнэт цаасны 2-р ангиллаас 1-р ангилал руу шилжлээ.
- 2019 оны эцсийн байдлаар Монголын Хөрөнгийн Бирж дээр идэвхитэй арилжигдсан үнэт цаасны жагсаалтад тоо ширхэгээрээ 1 дүгээрт, үнийн дүнгээрээ 4 дүгээрт эрэмбэлэгдлээ.
- “ЛэндМН ББСБ” ХК-ийн зах зээлийн үнэлгээ 34 тэрбум төгрөгт хүрч, Монголын Хөрөнгийн Бирж-д бүртгэлтэй 198 хувьцаат компаниас зах зээлийн үнэлгээгээрээ ТОП 13-т жагсаж байна.
- “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа хоёрдогч зах зээлд арилжаалагдаж эхэлснээс хойш 2019 оны эцэст 42.72 төгрөгт хүрч, 70.88%-иар өссөн байна.

Хувьцааны ханш



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж



Хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь

- Анд Системс ХХК
- Олон нийт

ИРО хийснээс хойш

70.88%

Ханшийн өсөлт


178'403'026 ш

Нийт арилжаалагдсан ширхэг


11'705'979'546₮

Нийт арилжаалагдсан үнийн дүн

Нэгж хувьцаанд ногдох ашиг (Төгрөг)



2019 онд нийт арилжигдсан тоо (Сая ширхэг)



2019 онд нийт арилжигдсан үнийн дүн (Тэрбум төгрөг)



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж



ХОЛБОО БАРИХ:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн
нарийн бичгийн дарга
Ж.Мөнхцэцэг

УТАС:

99018886

ИМЭЙЛ:

board@lend.mn